



НИЙТ ШҮҮГЧИЙН ЧУУЛГАНЫ ТОГТООЛ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийт шүүгчийн чуулганы 2021 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”-д дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/“1.3.6.“ээлжээр ажиллах шүүгч” гэж ажлын бус цагаар, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдөр сэжигтнийг баривчлах асуудлыг шийдвэрлэхээр тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилогдсон шүүгчийг ойлгоно.”

2/“1.4.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилоход хуульд заасан шаардлага хангасан программ хангамж ашиглана. Программ хангамжийн ажиллагаа болон аюулгүй байдлыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 71 дүгээр зүйлийн 71.1.12-т заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцна.”

3/“1.5.Шүүгчдийн зөвлөгөөнөөс энэхүү журамд нийцүүлэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг батална.”

4/“2.9.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээж авах хуваарь, бүртгэлийн үйл ажиллагаа зэрэг асуудлыг тухайн шүүхийн нарийвчилсан журмаар зохицуулна.”

5/“2.10.Хуульд заасан болон шүүгч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаас бусад тохиолдолд шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг алгасаж хуваарилахгүй.”

6/“2.11.Сэжигтнийг баривчлах, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын санал болон шүүхийн зөвшөөрлөөр хийгдэх ажиллагааг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан тухай прокуророос ирүүлсэн шийдвэрийг баривчлах ажиллагаа явагдсан газрын харьяалах шүүх тус тус хүлээн авч энэ журмын 2.2-т заасны дагуу хуваарилна.”

7/“2.12.Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах, эсхүл яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг тухайн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа газрын харьяалах шүүх хүлээн авч, энэ журмын 2.2-т заасны дагуу хуваарилна.”

8/“2.13.Зөрчлийн хэрэг, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эрүүгийн хэрэг, баривчлах, цагдан хорих тухай прокурорын санал зэргийг хэд хэдэн шүүгчийн дунд тусад нь тойрог үүсгэн хуваарилж болно.”

9/“2.14.Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан шийдвэрийг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хүлээж авах бөгөөд уг асуудлыг ажлын бус цагаар, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдөр хүлээн авч, шийдвэрлэх ээлжээр ажиллах шүүгчийн дарааллыг шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтооно.”

10/“3.6.Бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэрэг, маргаанд шүүх хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг тус тусад нь тойрог үүсгэн сонгож болно.”

11/“4.7.Шаардлага хангасан программ хангамжийг нэвтрүүлэх хүртэл хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг нарийвчилсан журмын дагуу сугалаагаар томилж болно.”

2.“Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”-ын 4.1 дэх хэсгийн “Ээлжийн” гэсний өмнө “Нарийвчилсан журамд” гэж, 4.5 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө “журам болон нарийвчилсан” гэж тус тус нэмсүгэй.

3.“Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”-ын дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/2.1 дэх хэсэг:

“2.1.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг тухайн шүүхийн шүүгчдээс урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор программ хангамж ашиглан шүүгчид хуваарилна. Шүүгч шинээр томилогдсон, сэлгэн ажилласан, шилжин томилогдсон тухай бүр шүүгчдийн нэрсийн дараалалд сугалаагаар оруулж, нэгдсэн системд байршуулна.”

2/2.2 дахь хэсэг:

“2.2.Шүүгчдийн зөвлөгөөнөөс нэгдсэн системд байрших тойрогт шүүгчийн нэрсийн дарааллыг сугалаагаар тогтоож, тайлангийн жил эхлэхээс өмнө нэгдсэн системд байршуулна.”

3/3.1 дэх хэсэг:

“3.1.Тухайн шүүхийн шүүгчдээс урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор программ хангамж ашиглан шүүх бүрэлдэхүүнийг томилно. Программ хангамж ашиглан томилох боломжгүй тохиолдолд шүүгчдийн зөвлөгөөнөөр урьдчилан тогтоосон нарийвчилсан журмын дагуу сугалаагаар шүүх бүрэлдэхүүнийг томилж болно.”

4.“Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”-ийн 1.3.4 дэх заалтын “нэгдсэн системийг ашиглан” гэснийг хассугай.

5.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж, мөрдсүгэй.

ДАРГАЛАГЧ

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke, positioned between the printed name and the title.

Д.БАТБААТАР